



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2014 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 117 дугаар тушаал, 2014 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн I/421 тоот мэдэгдэл, “Сикап” хязгаарлагдмал хариуцлагатай, “Эм Ай Си Си” хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Лайфтайм инвестмент” хязгаарлагдмал хариуцлагатай компаниудын арилжаанд оролцох эрхийг сэргээлгэх тухай хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Сикап” ХХК, “Эм Ай Си Си” ХХК, “Лайфтайм инвестмент” ХХК-иудын арилжаанд оролцох эрхийг 8 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг энэ тушаалын 1-т заасан гишүүн компаниудад анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР